

Үндэсний аудитын газар

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Аврах тусгай ангийн төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2017/138/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас:

Тэргүүлэх аудитор: С.Энхзаяа

Утас: 261663, 99117973 Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Болд

Утас: 262071, 99017100 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Аудитор: Б.Долгоржав Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn

Аудитор: Г.Жавхлан Цахим хаяг: javkhleng@audit.gov.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.12	Шилэн дансны мэдээлэл	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	12
3.1	«management_zurchil1»	
3.2	«management_zurchil2»	
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15

1 Аудитын гэрчилгээ

 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР 15100 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Баян толгой 3, Засгийн газрын IV байр, Утас: 26 04 37, Факс: (976) 6228 5230, E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn	ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА АВРАХ ТУСГАЙ АНГИЙН ЗАХИРАГЧ, ОНЦГОЙ БАЙДЛЫН ХУРАНДАА Д.НАМСРАЙ ТАНАА
2017.02.16 № 3/197 талай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аврах тусгай ангийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.	
Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл	
Аврах тусгай анги нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.	
Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.	
Санал дүгнэлтийн үндэслэл	
Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.	
Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.	
Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.	
U10.10.10.20Bichig_KheregiYawsan_Bichig20170216SAG3.Dook 073195	

Зөрчилгүй санал дүгнэлт

Аврах тусгай ангийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Аудитын тайланг ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн захирагч, Онцгой байдлын хурандаа Д.Намсрайд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Аврах тусгай ангийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аврах тусгай ангийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.01.25-наас 2017.02.25-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.02.25-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Долгоржав, аудитор Г.Жавхлан хариуцаж хэрэгжүүлэв.

Аврах тусгай ангийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.01.25-нд төрийн аудитын байгууллагад 2016.01.25-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж–Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Аврах тусгай анги “ Монгол Улсын нутаг дэвсгэрийн аль ч хэсэгт аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол түүнээс үүдэлтэй гамшгийн үед шуурхай шилжин байрлаж, эрэн хайх аврах, нэрвэгдэгсэдэд яаралтай тусламж үзүүлэх, аюулгүй газар зөөвөрлөх, эд хөрөнгийг нь авран хамгаалах” чиг үүргийг дэвшүүлсэн байна.

Аврах тусгай анги дээрх тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

- Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг удирдах, гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулах, тодотгох, түүнийг хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, гамшгаас хамгаалах сургалт, дадлага зохион байгуулах;
- Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед аврах ажиллагааг явуулахад аврах шуурхай бүлгийг удирдан зохион байгуулах, ажиллах нөхцлөөр хангах;
- Ангийн бүтэц, орон тоо, гүйцэтгэх үүргийг тодотгох, байгууллагын нөөц бүрдүүлэх;
- Ангийн гамшгаас хамгаалах бэлэн байдал, сэтгэл зүйн бэлтгэл, салбар, бүлгүүдийн харилцан шуурхай ажиллах чадварыг нэмэгдүүлэх, бэлэн байдлын үзлэг явуулах, аврах багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

- Өдөр тутмын үйл ажиллагаа, сургалт, дадлага, аюулт үзэгдэл, ослын үед үүрэг гүйцэтгэхэд ангийн бие бүрэлдэхүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах;
- Алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах болон холбогдох дүрэм журам зөрчигчдөд сахилгын шийтгэл ногдуулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд хяналт тавьж ажиллах

Аврах тусгай ангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Аврах тусгай ангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Төсвийн тухай хууль Нягтлан бодох
бүртгэлийн тухай хууль
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн болон орон
нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ
худалдан авах тухай хууль
Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аврах тусгай ангийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аудитын төлөвлөлтийн явцад Аврах тусгай ангийн санхүүгийн дотоод хяналтын тогтолцоог сайн гэж үнэлсэн ба гүйцэтгэл, тайлагналын үед дахин хянахад хэвийн байна.

Аврах тусгай ангийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд хэвийн буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Аврах тусгай анги санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн ""Санхүүгийн

тооцоолох" ХХК-ний нягтлан бодох бүртгэлийн Аколус програм програм хангамж ашиглажээ.

Тус програм нь Аврах тусгай ангийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг ба Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аврах тусгай ангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 1 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 1 асуудал эрсдэл өндөр, 1 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 3 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 2 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих, шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас материаллаг байдлын суурь үзүүлэлтийг тооцлоо.

Аврах тусгай ангийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4.0 тэрбум төгрөг бөгөөд түүний 2 хувь 81.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг нийт зардлын 2 хувиар тооцох нь зохимжтой гэж үзэв.

Гүйцэтгэлийн үе шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг зүйлс илэрсэнгүй.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 2 чиглэлээр 2 эрсдэлтэй асуудалд 2 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 66 хувь буюу 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2	108.9	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	2	108.9	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Үүнд:

ОБЕГ-ын даргын 2016 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн Б/59 дугаар тушаалын дагуу Мэргэжил дээшлүүлэх давтан сургалтын төвийн төрийн үйлчилгээний 21 албан хаагчдын цалинд 88.8 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх

ОБЕГ-аас Аврах тусгай ангид ирүүлсэн албан бичгийн дагуу НОБГ-т 20.1 сая төгрөгийн НДШ-ийн зардлыг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй болно.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал байхгүй болно.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Аврах тусгай анги өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 2,938,927,400.00, хөрөнгийн зардалд 0.00 төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2938927400	2935127399.48	-0.12%	-3800000.5
1.1	Урсгал зардал	2938927400	2935127399.48	-0.12%	-3800000.5
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос				

Төсөвт зардлын гүйцэтгэлийг 0.12 хувиар хэмнэсэн нь НДШ-ийн зардал 54.0 сая төгрөгөөр хэмнэгдсэнийг улсын төсөв рүү төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлого батлагдаагүй байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 120,546,499.0 төгрөг зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Аврах тусгай анги Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлтэй асуудал илэрсэнгүй.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх аудитаар Аврах тусгай ангид бие даасан аудитын дүгнэлт гаргаагүй бөгөөд ҮАГ-аас Монгол Улсын Шадар сайдын багцад хийсэн гэрчлэх аудитын хүрээнд аудитын түүвэрт хамрагдсан байна.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Аврах тусгай ангийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аврах тусгай ангийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Аврах тусгай ангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Цалин

Илрүүлэлт

Зөвлөмж

ОБЕГ-ын даргын 2016 оны 02 дугаар Төсвийн тухай хууль тогтоомжийг сарын 04-ны өдрийн Б/59 дугаар мөрдөж ажиллах тушаалын дагуу Мэргэжил дээшлүүлэх давтан сургалтын төвийн төрийн үйлчилгээний 21 албан хаагчдын цалинд 88.8 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Хариуцах ажилтан

ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн захирагч, Онцгой байдлын хурандаа Д.Намсрай, ахлах нягтлан бодогч, Онцгой байдлын дэд хурандаа Г.Батбаатар

Эрсдэл

Төсвийн захирагчийн хариу

Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх Аудитаар илэрсэн материаллаг бус зөрчлийг ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 НДШ

Илрүүлэлт

ОБЕГ-аас Аврах тусгай ангид ирүүлсэн албан бичгийн дагуу НОБГ-т 20.1 сая төгрөгийн НДШ-ийн зардлыг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Төсвийн тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллах

Хариуцах ажилтан

ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн захирагч, Онцгой байдлын хурандаа Д.Намсрай, ахлах нягтлан бодогч, Онцгой байдлын дэд хурандаа Г.Батбаатар

Эрсдэл

Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн материаллаг бус зөрчлийг ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

СТ-1А

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,342,950,136.85</u>	<u>1,225,157,106.87</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	381,238,098.87	72,229,380.25
351	Түүхий эд материал	15,053,750.67	13,625,781.27
35110	Тусгай зориулалттай материал	10,925,500.00	9,888,000.00
35130	Эм боох материал	4,128,250.67	3,737,781.27
354	Хангамжийн материал	364,274,348.20	56,648,598.98
35410	Бичиг хэргийн материал	2,540,642.00	3,108,385.00
35420	Аж ахуйн материал	17,048,577.00	29,606,557.98
35430	Сэлбэг хэрэгсэл	1,044,570.00	1,044,570.00
35440	Түлш, шатах тослох материал	6,066,480.00	10,092,189.00
35450	Барилгын засварын материал	8,008,316.00	8,666,216.00
35460	Хүнсний материал	1,148,375.00	2,815,691.00
35470	Бусад хангамжийн материал	328,417,388.20	1,314,990.00
35600	Мал амьтад	1,910,000.00	1,955,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	961,712,037.98	1,152,927,726.62
36100	Барааны нөөц	961,712,037.98	1,152,927,726.62
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,601,219,681.36</u>	<u>3,249,620,876.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,601,219,681.36	3,249,620,876.97
392	Биет хөрөнгө	3,601,219,681.36	3,249,620,876.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,072,891,260.00	4,072,891,260.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,838,393,383.88	-1,905,679,809.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	780,397,143.50	780,397,143.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	-381,668,559.81	-496,222,143.33
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,131,757.24	45,131,757.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-39,847,586.76	-44,497,057.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	153,863,723.34	153,863,723.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	-109,293,733.02	-120,860,794.45
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	2,247,138,242.03	2,394,794,686.03
39212	Хуримтлагдсан элэгдэл	-1,365,152,512.26	-1,657,999,219.33
39214	Бусад үндсэн хөрөнгө	58,356,000.00	58,356,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-24,168,416.98	-33,345,417.10
39217	Ном	1,965,747.96	2,790,747.96
393	Биет бус хөрөнгө	0.00	0.00
39301	Програм хангамж	1,425,000.00	1,425,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,425,000.00	-1,425,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,944,169,818.21</u>	<u>4,474,777,983.84</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,656,664.00</u>	<u>0.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,656,664.00	0.00

Аврах тусгай ангийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит			

413	Өглөг	1,656,664.00	0.00
4136	Бусад өглөг	1,656,664.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,656,664.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,942,513,154.21	4,474,777,983.84
51	Засгийн газрын хувь оролцоо	4,942,513,154.21	4,474,777,983.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		4,137,492,525.87	4,137,492,525.87
51101	Өмч: - төрийн	4,137,492,525.87	4,137,492,525.87
512	Хуримтлагдсан үр дүн	-119,868,899.37	-587,604,069.74
51210	Өмнөх үеийн үр дүн	-119,868,899.37	-125,559,347.67
51220	Тайлант үеийн үр дүн		-462,044,722.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	924,889,527.71	924,889,527.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,944,169,818.21	4,474,777,983.84

СТ-2А

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,388,776,764.12	3,613,499,496.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	848,575,934.55	411,369,153.74
120	Нийтлэг татварын бус орлого	848,575,934.55	411,369,153.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	848,575,934.55	411,369,153.74
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,080,000.00	1,200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	847,495,934.55	410,169,153.74
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,540,200,829.57	3,202,130,343.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,455,398,040.00	3,081,583,844.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,176,392,710.00	2,933,927,400.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	279,005,330.00	147,656,444.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,802,789.57	120,546,499.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,246,916.00	120,546,499.00
131106	Төсвийн урамшуулал	555,873.57	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,806,498,531.73	4,075,544,218.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,806,498,531.73	4,075,544,218.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,580,297,374.16	4,023,584,981.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,480,568,752.00	2,429,045,400.00
210101	Үндсэн цалин	2,185,428,756.00	2,034,710,832.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	95,280,811.00	104,067,550.00
210105	Гэрээт ажлын хөлс	199,859,185.00	290,267,018.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,671,302.00	171,963,703.81
210201	Тэтгэврийн даатгал	21,748,483.00	117,394,227.81
210202	Тэтгэмжийн даатгал	1,042,063.00	1,711,425.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,084,126.00	3,422,850.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,042,063.00	1,711,425.00
210205	Эрүүл мэндийн даатгал	49,754,567.00	47,723,776.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,356,156.00	148,557,955.96
210301	Гэрэл, цахилгаан	24,801,870.00	27,273,247.00
210302	Түлш, халаалт	197,040,293.00	120,908,964.96
210303	Цэвэр, бохир ус	1,513,993.00	375,744.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,810,431.00	28,442,226.67
210401	Бичиг хэрэг	2,916,738.00	2,368,100.00
210402	Тээвэр, шатахуун	27,506,000.00	21,473,650.00

Аврах тусгай ангийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит			
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,097,963.00	4,600,476.67
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	289,730.00	
2105	Нормативт зардал	53,101,013.13	461,716,667.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	514,052.03	2,690,469.40
210502	Хоол, хүнс	29,943,438.00	12,062,824.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,643,523.10	446,963,374.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,551,176.40	81,203,010.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,925,600.00	1,323,950.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	59,649,757.40	2,743,410.00
210604	Урсгал засвар	12,975,819.00	77,135,650.00
2107	Томилолт, зочны зардал	81,345,800.00	48,278,500.00
210702	Дотоод албан томилолт	81,345,800.00	48,278,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,251,113.00	23,075,197.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	700,000.00	575,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	18,029,849.00	14,186,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,797,100.00	1,451,933.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	304,000.00	209,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,088,500.00	521,000.00
210807	Газрын төлбөр	6,131,664.00	6,131,664.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	522,641,630.63	631,302,320.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		76,602,150.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	83,663,600.00	60,310,370.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	438,978,030.63	494,389,800.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	226,201,157.57	51,959,237.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,205,373.57	515,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,855,373.57	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.00	515,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	215,995,784.00	51,444,237.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	215,995,784.00	51,444,237.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	582,278,232.39	-462,044,722.07
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	582,278,232.39	-462,044,722.07

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,261,388,183.57	3,055,673,899.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,080,000.00	1,200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,080,000.00	1,200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,080,000.00	1,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,080,000.00	1,200,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,260,308,183.57	3,054,473,899.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,176,392,710.00	2,933,927,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,176,392,710.00	2,933,927,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83,915,473.57	120,546,499.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,237,800.00	120,546,499.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,121,800.00	
131106	Төсвийн урамшуулал	555,873.57	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,261,388,183.57	3,055,673,899.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,261,388,183.57	3,055,673,899.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,033,741,026.00	3,004,229,661.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,487,728,356.00	2,429,045,400.00
210101	Үндсэн цалин	2,192,588,360.00	2,034,710,832.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	95,280,811.00	104,067,550.00
210105	Гэрээт ажлын хөлс	199,859,185.00	290,267,018.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,511,698.00	171,963,703.81
210201	Тэтгэврийн даатгал	14,588,879.00	117,394,227.81
210202	Тэтгэмжийн даатгал	1,042,063.00	1,711,425.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,084,126.00	3,422,850.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,042,063.00	1,711,425.00
210205	Эрүүл мэндийн даатгал	49,754,567.00	47,723,776.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,785,087.00	143,300,891.00
210301	Гэрэл, цахилгаан	24,801,870.00	27,273,247.00
210302	Түлш, халаалт	159,469,224.00	115,651,900.00
210303	Цэвэр, бохир ус	1,513,993.00	375,744.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,915,077.00	30,896,695.67
210401	Бичиг хэрэг	2,576,900.00	2,484,370.00
210402	Тээвэр, шатахуун	26,254,800.00	23,348,649.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,088,847.00	4,600,476.67

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	994,530.00	463,200.00
2105	Нормативт зардал	14,980,500.00	14,230,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,755,500.00	2,300,000.00
210502	Хоол, хүнс	8,210,000.00	10,148,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,015,000.00	1,782,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,091,199.00	78,276,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,280,600.00	2,003,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		545,500.00
210604	Урсгал засвар	10,810,599.00	75,727,200.00
2107	Томилолт, зочны зардал	81,345,800.00	48,688,500.00
210702	Дотоод албан томилолт	81,345,800.00	48,688,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,894,449.00	24,635,361.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	18,029,849.00	14,186,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,797,100.00	1,451,933.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	304,000.00	209,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,088,500.00	999,500.00
210807	Газрын төлбөр	4,475,000.00	7,788,328.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,488,860.00	63,192,010.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	120,488,860.00	63,192,010.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	227,647,157.57	51,444,237.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,651,373.57	0.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,651,373.57	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	215,995,784.00	51,444,237.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	215,995,784.00	51,444,237.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	0.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	0.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,137,492,525.87	924,889,527.71	-702,147,131.76		4,360,234,921.82
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,137,492,525.87	924,889,527.71	-702,147,131.76	0.00	4,360,234,921.82
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			582,278,232.39		582,278,232.39
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,137,492,525.87	924,889,527.71	-119,868,899.37	0.00	4,942,513,154.21
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,137,492,525.87	924,889,527.71	-119,868,899.37	0.00	4,942,513,154.21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-5,690,448.30		-5,690,448.30
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,137,492,525.87	924,889,527.71	-125,559,347.67	0.00	4,936,822,705.91
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-462,044,722.07		-462,044,722.07
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,137,492,525.87	924,889,527.71	-587,604,069.74	0.00	4,474,777,983.84

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,938,927,400.00	2,935,127,399.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,938,927,400.00	2,935,127,399.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,933,927,400.00	2,883,683,162.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,429,045,400.00	2,429,045,400.00
210101	Үндсэн цалин	2,176,658,200.00	2,034,710,832.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	102,836,100.00	104,067,550.00
210105	Гэрээт ажлын хөлс	149,551,100.00	290,267,018.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	226,283,400.00	171,963,703.81
210201	Тэтгэврийн даатгал	110,269,800.00	117,394,227.81
210202	Тэтгэмжийн даатгал	20,779,600.00	1,711,425.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,882,100.00	3,422,850.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,327,000.00	1,711,425.00
210205	Эрүүл мэндийн даатгал	47,024,900.00	47,723,776.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,300,900.00	143,300,891.00
210301	Гэрэл, цахилгаан	30,678,500.00	27,273,247.00
210302	Түлш, халаалт	111,595,600.00	115,651,900.00
210303	Цэвэр, бохир ус	1,026,800.00	375,744.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,946,700.00	29,946,696.67
210401	Бичиг хэрэг	2,804,200.00	2,484,370.00
210402	Тээвэр, шатахуун	22,400,100.00	22,398,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,649,800.00	4,600,476.67
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,092,600.00	463,200.00
2105	Нормативт зардал	13,390,500.00	13,390,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,400,000.00	2,300,000.00
210502	Хоол, хүнс	8,975,000.00	9,308,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,015,500.00	1,782,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,900,400.00	7,276,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,465,000.00	2,003,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,134,500.00	545,500.00
210604	Урсгал засвар	5,300,900.00	4,727,200.00
2107	Томилолт, зочны зардал	933,300.00	932,000.00
210702	Дотоод албан томилолт	933,300.00	932,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,611,000.00	24,635,361.00

Аврах тусгай ангийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит			
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	14,186,600.00	14,186,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,956,000.00	1,451,933.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	480,000.00	209,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	999,500.00
210807	Газрын төлбөр	7,788,400.00	7,788,328.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,515,800.00	63,192,010.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,350,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,165,800.00	63,192,010.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,000,000.00	51,444,237.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	51,444,237.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		51,444,237.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00	0.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,000,000.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,938,927,400.00	2,935,127,400.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,938,927,400.00	2,933,927,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,938,927,400.00	2,933,927,400.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	1,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,200,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	227.00	257.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	202.00	202.00
620003	Үйлчлэх ажилтан	24.00	54.00